



SILVER.CO



# \$MNFT ТАНИЛЦУУЛЖ БАЙНА

MongolNFT төслөөс гаргаж буй засаглал, хэрэглээний койн



POWERED BY: Mongol NFT  
[www.mongolnft.com](http://www.mongolnft.com)



# АГУУЛГА

- Өнөөгийн NFT ертөнц
- Тулгарч буй томоохон асуудлууд ба шийдлүүд
- \$MNFT-г танилцуулж байна
- Койны засаглал ба хэрэглээ
- Койны хуваарилалт
- Ойрын болон хэтийн төлөвлөгөө
- Манай баг хамт олон
- Гэрээний нөхцөлүүд



# ӨНӨӨГИЙН **NFT** ЕРТӨНЦ

# ӨНӨӨГИЙН NFT ЕРТӨНЦ

- NFT гэж юу вэ?
- NFT хэрхэн яаж ажилладаг вэ?
- NFT-г юунд ашигладаг вэ?
- NFT болон крипто валютын ялгаа юу вэ?
- NFT ертөнцийн ирээдүй

# NFT ГЭЖ ЮУ ВЭ?

**NFT гэдэг нь "non-fungible token" буюу хувиршгүй токен гэсэн үгсийн товчлол юм.**

Ерөнхийдөө NFT гэдэг ойлголтыг өнөө цагийн цуглуулга гэж ойлгож болох юм. Энэхүү цуглуулгаа онлайнаар худалдан авах, зарах боломжтой бөгөөд урлагийн бүтээл, үл хөдлөх хөрөнгө, дуу хөгжим, бичлэг гээд ямар ч хөрөнгийн өмчлөлийн нотлох баримтыг дижитал хэлбэрээр харуулж чаддагаараа онцлогтой. NFT нь крипто валютуудын адил блокчейн технологи дээр суурилсан бөгөөд ингэснээрээ тухайн хөрөнгийг цор ганц гэдгийг нь батлах боломж бүрддэг. Тийм ч учраас блокчейн технологийн хүрээнд өөрчлөх болон хуурамчаар NFT бүтээх нь бараг боломжгүй юм.

NFT-г илүү сайн ойлгохын тулд эхлээд ямарваа нэг хөрөнгийн хувирах шинж чанарын талаар ойлгох хэрэгтэй.

**FUNGIBLE**
**NON-FUNGIBLE**

**PHYSICAL**

**DIGITAL**

## ХУВИРАХ ХӨРӨНГӨ

Эдийн засгийн хүрээнд хувирах хөрөнгө гэдэг нь өөр ижил үнэтэй эд зүйл/хөрөнгөөр солих боломжтой хөрөнгийг хэлдэг. 1 долларын дэвсгэртийг дахиад өөр 1 долларын дэвсгэртэй харьцуулахад ямар ч ялгаагүй байдаг нь мөнгө гэх хувирах хөрөнгийн нэг жишээ юм. Яг түүнтэй адилаар, нэг компаниас авсан нэг ижил төрлийн хувьцаа, ижил чанартай бараа бүтээгдэхүүнүүд гэх мэт зүйлсийг ерөнхийд нь хувирах хөрөнгө гэж ойлгож болно.

## ХУВИРШГҮЙ ХӨРӨНГӨ

Нөгөө талаас, Леонардо Да Винчигийн Мона Лиза бүтээл бол цор ганц байдаг, дахин бүтээгдэх боломжгүй учраас хувиршгүй хөрөнгө гэж ойлгож болно. NFT гэдэг нь яг үүнтэй адилхан дахин хийгдэх боломжгүй, цор ганц байх хөрөнгө бөгөөд дижитал ертөнцөд үүнийг жинхэнэ мөнгөөр худалдан авч, зарах боломжтой юм.

# NFT ХЭРХЭН ЯАЖ АЖИЛЛАДАГ ВЭ?

Ихэнхи NFT-г Ethereum сүлжээн дээр үүсгэж, хадгалсан байдаг ч, Flow, Tezos гэх мэт блокчейнүүд дээр NFT үүсгэх боломж бий. Хэн ч блокчейн рүү орж үзэх боломжтой байдаг учраас тухайн NFT-г өмчилсөн эзнийг шалгах, мөшгих амархан. Үүнээс гадна NFT-ийн эзэмшигч нь өөрийн мэдээллээ нууцлах, нийтэд ил харагдуулахгүй байх боломж нь бүрэн нээлттэй.

NFT байршиж байгаа технологи, концепц цаашдаа сайжрах, хөгжих тусам зөвхөн урлагаар хязгаарлагдахгүй болж байна. Жишээ нь, сургуулиуд оюутнуудад дипломын оронд NFT олгож, уг NFT-ээр ажил олгогчид тухайн оюутны боловсролын зэргийг илүү амархан шалгах боломжтой. Түүгээр ч зогсохгүй, концерт, тоглолтын тасалбарыг NFT болгон зарж, удирдсанаар шаглаж зарах гэсэн ойлголтыг байхгүй болгох боломж бүрдэнэ.





# NFT-Г ЮУНД АШИГЛАДАГ ВЭ?

Блокчейн технологи болон NFT-н тусламжтай уран бүтээлчид өөрийн бүтээлээ маш өвөрмөц байдлаар борлуулах боломжтой. Жишээ нь, уран бүтээлчид заавал галлерей, дуудлага худалдааны газруудад найдалгүй өөрөө эцсийн хэрэглэгч рүү NFT болгон бүтээлээ зарж, илүү ашиг олох боломжтой. Түүгээр ч зогсохгүй, роялти хөтөлбөр үүсгэн, бүтээл нь нэг хүнээс нөгөө хүнд зарагдах болгонд тодорхой хувийг нь анхны бүтээгч авдаг болгож болно. Бараг ямар ч тохиолдолд уран бүтээлчид бүтээлээ нэг зарсан бол дахин тухай тухайн бүтээлээс орлого олох боломжгүй байдаг тул NFT нь уран бүтээлчдэд ашигтай тусдаг билээ.

NFT нь ямар ч төрлийн дижитал хөрөнгө байх боломжтой учраас үүнийг ашиглан ашиг олох маш олон боломж бий. Өдийг хүртэл дараах зүйлсийг NFT болгон гаргаж байна:

- Цуглуулга
- Дуу хөгжим,
- Тоглоом ба тоглоом доторх худалдан авалтууд
- Тасалбар
- Жинхэнэ амьдрал дээрх болон Metaverse дээрх хөрөнгүүд
- Виртуал эд зүйлс


Үнэ цэнэ нь байнга өөрчлөгдөх боломжтой учраас урлагийн бүтээл бол хувиршгүй хөрөнгийн нэг тод жишээ юм. Тийм ч учраас урлагийн бүтээлүүдийг NFT болгож арилжаалах нь нийтлэг, ашигтай бизнес болоод байна. NFT дижитал урлагийн бүтээлүүдийн зарим нэг жишээнүүдээс...




Christie's дуудлага худалдаагаар дижитал уран бүтээлч Beeple өөрийнхөө "Everydays — the First 5000 Days" гэх бүтээлийг 69.3 сая ам. доллараар заржээ.



LeBron James-ийн "Cosmic Dunk #29" нэртэй 20 секундын бичлэг 208,000 ам. доллараар зарагджээ.



CryptoPunks NFT нь Sotheby-н анхны худалдаанд 1.8 сая ам. доллараар зарагджээ.



Twitter-ийн гүйцэтгэх захирал Jack Dorsey өөрийнхөө хамгийн анхны tweet-г 2.9 сая ам. доллараар зарсан байна.



Grimes 6 сая ам. долларын үнэд хүрэх дижитал бүтээлүүдээ NFT болгон зарсан байна.

# NFT БОЛОН КРИПТО ВАЛЮТЫН ЯЛГАА ЮУ ВЭ?

NFT болон крипто валют гэх 2 ойлголт нь хоёулаа блокчейн технологи дээр суурилсан байдаг. Мөн NFT-г худалдаж авахдаа крипто валют ашиглан худалдаж авах шаардлагатай үүсч болно.

Гэхдээ крипто валют болон NFT нь тус бүр өөр зорилгоор бүтээгдэж, бас өөр зорилгоор ашиглагддаг.

Крипто валют нь мөнгө шиг тодорхой үнэ цэнийг хадгалах эсвэл ямар нэгэн зүйлийг худалдан авах, зарахад ашиглагддаг. Крипто валютын токен нь төгрөг шиг фиат валют бөгөөд хувирах хөрөнгө юм.

Нөгөө талаас, NFT бүхэн өөрийн гэсэн дижитал шинж тэмдэгтэй байдаг учраас нэг NFT-г нөгөөгөөр солих гэсэн ойлголт байхгүй (тиймдээ ч non-fungible буюу хувиршгүй болж байгаа юм). NBA-ийн Top Shot бичлэг, Beeple-ийн "Everydays — the First 5000 Days" гэсэн 2 бүтээл хоёулаа NFT болохоор адилхан гэж харах үндэслэл байхгүй гэсэн үг.

# NFT ЕРТӨНЦИЙН ИРЭЭДҮЙ



NFT гэдэг ойлголт нь шинээр гараад удаагүй байгаа ч маш хурдтайгаар хөгжиж байгаа. Уран баримал, уран зураг, дуу хөгжим гэх мэт бүтээлүүд зарагдаж эхэлсэн энэхүү экосистемд шинээр маш олон үүсгэн байгуулагчид, уран бүтээлчид, одууд, болон хөрөнгө оруулагчид нэвтэрсээр л байна.

Панкууд, муурнууд, NBA-н slam dunk бичлэгүүдээс эхлээд барьцаат зээл, виртуал пүүз, metaverse дээрх дижитал газар гээд NFT экосистем нь таамаглашгүй олон талууд руу хөгжиж, дуусашгүй боломжуудыг гаргаж ирсээр байна.

# ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД БОЛОН ШИЙДЛҮҮД



# ТУЛГАРЧ БУЙ ТОМООХОН АСУУДЛУУД БА ШИЙДЛҮҮД

- Монголын уран бүтээлчдэд тулгарч буй асуудлууд
- Өөрчлөлтийг авчрагч MongoINFT
- Бидний шийдлүүд
- Өнөөдрийг хүртэл MongoINFT төслийн зүгээс хийсэн зүйлс

# МОНГОЛЫН УРАН БҮТЭЭЛЧДЭД ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД

Сүүлийн хэдэн сарын турш NFT-н ертөнц эрчээ авч, дэлхий даяар томоохон одууд, уран бүтээлчид, болон хөрөнгө оруулагчид NFT зарж сая сая долларын ашиг хийчихээд байна.

Монголд NFT зарж борлуулах зах зээлийн дэд бүтэц, системчлэгдсэн мэдээлэл байхгүйн улмаас энэхүү ертөнцөд хөл тавих сонирхолтой уран бүтээлчид болон контент бүтээгчид зөвхөн OpenSea, Rarible, SuperRare, Foundation гэх мэт гадны зах зээл рүү орохоос өөр аргагүй болж, үүнээс үүдээд тодорхой хэмжээний асуудлууд үүсдэг.

Харин одоо...

# МОНГОЛЫН УРАН БҮТЭЭЛЧИД ӨӨРСДИЙН БҮТЭЭЛИЙГ ТЕХНОЛОГИЙН ТУСЛАМЖТАЙГААР, АЛБАН ЁСООР, ХУУЛЬ ЁСНЫ ДАГУУ МӨНХЛӨХ ЦОР ГАНЦ ГАЗАР.

Энэхүү асуудлуудыг шийдэж, Монголчууддаа хязгааргүй олон боломжуудыг NFT-н тусламжтайгаар хүргэхийн тулд бид Монголын хамгийн анхны NFT зах зээл болох "MongolNFT"-г танилцуулаад байгаа билээ. MongolNFT дээр хэрэглэгчид дижитал урлагийн бүтээлүүдийг худалдан авч, зараад зогсохгүй инфлүэнсэрүүд, контент бүтээгчид өөр хаана ч байхгүй онцгой бүтээлүүдээ сурталчилж, дагагчид болон фенүүдтэйгээ харилцаа үүсгэх өвөрмөц аргыг нээж өгч байгаа юм.

Тэгэхээр, эдгээр асуудлуудыг бид хэрхэн шийдэх вэ?



# БҮТЭЭЛИЙН ЖИНХЭНЭ БАЙДАЛ

## АСУУДАЛ

NFT дээр урлагийн бүтээлийн хулгай гэх томоохон асуудал байдаг. Өөрөөр хэлбэл, хэн нэгний гаргасан бүтээлийг хэн ч хуулаад, өөр зах зээл дээр шинэ токен үүсгэж гаргаад, зарж болно.

Тиймээс худалдан авагчид өөрсдөө жинхэнэ урлагийн бүтээлийн эзнийг олж, баталгаажуулах илүү ажилтай нүүр тулдаг.

## БИДНИЙ ШИЙДЭЛ

Хууль ёсны этгээдийн хувьд, бид бүх бүтээгчидтэй албан ёсоор гэрээ байгуулж, зохиогчийн эрхийг зөрчих боломжуудыг гэрээгээрээ маш хатуу дүрмийн дор урьдчилан сэргийлдэг.

Нөгөө талаас, MongolNFT дээрх худалдан авагчид заавал зохиогчийн эрх, болон бүтээлийн жинхэнэ байдалд санаа зовох шаардлагагүй болж байгаа юм.



# ДЭЛХИЙ ДАХИНД ТАНИГДААГҮЙ БАЙДАЛ

## АСУУДАЛ

Монгол дахь уран бүтээлчид болон контент бүтээгчид дэлхийд сайн танигдаж амжаагүй учраас дэлхий дахинд томоохон зах зээл дээр гарахад тэдний бүтээлүүдийн эрэлт тийм ч өндөр биш байж болох юм.

Олон улсын томоохон зах зээлүүд дээр өрсөлдөөн өндөр, өдөр болгон маш олон тооны бүтээлүүд тавигддаг. Ийм нөхцөлд нэмэлт төлбөр төлж, бүтээлүүдээ гаргасан ч, зарагдахгүй байвал зүгээр л мөнгөө салхинд хийсгэж байгаа мэт болох нь элбэг.

## БИДНИЙ ШИЙДЭЛ

MongoNFT-ийн хамт олон бид Монголынхоо уран бүтээлчид, контент креаторс-н бүтээлүүдийг дэлхийд гаргах, олон талт байдлаар маркетинг хийн нэг урсгалаар сурталчаах гэх зэрэг боломжудыг олгож байгаа юм.

# ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ

## АСУУДАЛ

Олон улс дахь худалдан авагчид NFT-ийнхээ жинхэнэ бүтээгчийг баталгаажуулсны дараа зарим тохиолдолд тухайн уран бүтээл нэгээс олон зохиогчтой байдгаас шалтгаалан зохиогчийн эрхийн асуудал үүсдэг.

Тухайн уран бүтээлд гуравдагч этгээд ямар нэгэн байдлаар оролцсон байх боломжтой тул бүтээл тус бүр дээр зохиогчийн эрхийн асуудал яригдахаас өөр аргагүй болдог.

## БИДНИЙ ШИЙДЭЛ

Технологийн талаас нь харахад , MongolNFT дээр орж байгаа бүх урлагийн бүтээлүүд болон контентууд нь блокчейн систем дээр бүртгэгдэж, "ухаалаг" гэрээний тусламжтайгаар бүтээгч болон худалдан авагчийг зохиогчийн эрхийн зөрчлөөс урьдчилан хамгаалж байгаа юм.

# ӨНДӨР ШИМТГЭЛ

## АСУУДАЛ

Ихэнхи алдартай NFT зах зээлүүд ETH блокчейн дээр ажилладаг учраас "gas fee" (гүйлгээ хийхэд авч буй шимтгэл), "mint fee" (урлагийн бүтээлийг шинээр блокчейн дээр үүсгэхэд авч буй шимтгэл) гэх мэт нэмэлт төлбөрүүд нь маш өндөр байдаг.

## БИДНИЙ ШИЙДЭЛ

Бид гэрээ хийж байгаа уран бүтээлчиддээ олон төрлийн MultiChain-г санал болгодог бөгөөд үүнд ETH блокчейнээс гадна Binance Smart Chain (gas fee багатай), Polygon, Terra, Solana (mint fee багатай) гэх мэт системүүд багтсан байгаа.

# ӨНӨӨДРИЙГ ХҮРТЭЛ MONGOLNFT-Н ХИЙСЭН ЗҮЙЛС

Үүсгэн байгуулагдсанаас хойш сар хүрэхгүй хугацаанд MongolNFT нь:

- 8,500 гаруй хэрэглэгчдийг нэмэлт маркетинг хийлгүйгээр татаж чадсан бөгөөд дараагийн сардаа багтааж 5,000 гаруй хэрэглэгчдийг нэмж татан, 13,500 идэвхитэй хэрэглэгчтэй болох хандлагатай байгаа.
- Эхний сар дотроо нийт 4,000 NFT гаргаж, бүгд хэдхэн цагийн дотор зарагдаж дууссан.
- Discord дээр уран бүтээлчид, урлаг сонирхогчид болон NFT-д итгэгч 6,500 гаруй гишүүнтэй хамт олныг цуглуулж чадсан.

**8'500**

ОРГАНИК ХЭРЭГЛЭГЧИД

**4000+**

НИЙТ NFT

**ЭХНИЙ 2 ЦАГТАА  
ЗАРАГДАЖ ДУУССАН  
(дунджаар)**

СТАТУС

**6500+**

DISCORD ДЭЭРХ ГИШҮҮДИЙН ТОО

# \$MNFT-Г ТАНИЛЦУУЛЖ БАЙНА




# \$MNFT КОЙНЫГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА

ХЭРЭГЛЭГЧИДДЭЭ БИД ЭЗЭМШИЖ БУЙ ТОКЕНЬХОО ОЛОН ТӨРЛИЙН ХЭРЭГЛЭЭНЭЭС АШИГ ТУСЫГ НЬ ХҮРТЭХ, MONGOLNFT ДЭЭРХ ИДЭВХИЙГ НЬ УРАМШУУЛАХ ГЭХ БОЛОМЖУУДЫГ НЭЭЖ ӨГӨХ ҮҮДНЭЭС ӨӨРСДИЙН \$MNFT КОЙНОО ТАНИЛЦУУЛЖ БАЙГААДАА БАЯРТАЙ БАЙНА.

\$MNFT КОЙН НЬ BINANCE SMART CHAIN ДЭЭР BEP-20, ETHEREUM CHAIN ДЭЭР ERC-20 ДЭЭР УДАХГҮЙ ГАРАХ БОЛНО.

# \$MNFT-Н ХЭРЭГЛЭЭ

## MONGOLNFT ЗАХ ЗЭЭЛ



## NFT-Р ДАМЖУУЛАН ОРДОГ ВИДЕО СТРИЙМИНГ ПЛАТФОРМУУД



## ТОГЛООМ



## METAVVERSE ДЭЭРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУД



ГЭХ МЭТ МАШ ОЛОН  
БОЛОМЖУУД...

- DAO
- СТРАТЕГИЙН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

# КОЙНЫ ЗАСАГЛАЛ БА ХЭРЭГЛЭЭ



# КОЙНЫ ЗАСАГЛАЛ

Бид илүү олуулаа болж, зах зээл дээрх өөрсдийн байр сууриа өргөжүүлсээр, DAO (Decentralized Autonomous Organisation) буюу төвлөрсөн бус автономит байгууллага болохоор хичээн ажиллаж байгаа билээ. Койн эзэмшигчид нь MongolNFT marketplace болон удахгүй бий болох платформуудын захиргаа, шинэчлэн сайжруулалт болон цаашдаа хэрхэн яаж хөгжих тал дээр өөрсдийн саналыг дэвшүүлж, санал хураалтад оролцох боломжтой болно. Ингэснээр MongolNFT платформыг хамгийн үнэн ч хэрэглэгчид нь хариуцаж эхлэхэд нэгээхэн алхам ойртож байгаа юм. \$MNFT койн эзэмшигчид дараах саналуудад өөрийн хувь нэмрээ оруулах боломжтой:

## I. СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛД САНАЛАА ӨГӨХ

- MongolNFT дээр арилжаа хийх шимтгэл
- MongolNFT дээр шинээр оруулж болох нэмэлт хөгжүүлэлтүүд
- \$MNFT-н засаглал болон MongolNFT зах зээлийн хөгжүүлэлтийг бүр илүү төвлөрсөн бус болгохын тулд яаж ашиглахыг шийдэх гэх мэт...

## II. ПЛАТФОРМ ДЭЭРХ БҮТЭЭГЧДИЙГ УДИРДАХ

- Шинэ уран бүтээлчид болон NFT бүтээлүүдийг MongolNFT-д санал болгох
- Бүтээлчдийг платформ дээр баталгаажуулах

## III. ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ТӨСЛҮҮДЭД САНАЛАА ӨГӨХ

Бид 2022 оны эхний хагасаас эхлээд BoredApes Yacht Club, CryptoPunks гэх мэт дэлхийн томоохон NFT коллекциудад хөрөнгө оруулахаар төлөвлөж байгаа билээ. Үүнтэй адилхан ирээдүйн стратеги хөрөнгө оруулалтуудад \$MNFT койны эзэмшигчид санал бодлоо илэрхийлэх боломжтой.

Эхний ээлжинд дээрх саналууд нь хэрэглэгчид маань зөвлөх маягаар ажиллах бөгөөд хэрэглэгчдийн хүсэл сонирхлыг бидэнд хүргэх зорилготой байна. Эдгээр саналуудыг ихэнхи тохиолдолд бид дагаж мөрдөх боловч заавал дагах шаардлагагүй тохиолдол байж болно.

# КОЙНЫ ХЭРЭГЛЭЭ

\$MNFT койн нь бусад крипто валютуудын үндсэн шинж чанарыг агуулахаас гадна хамгийн чухал онцлог нь MongolNFT -н платформуудад ашиглагдах шууд хэрэглээ нь юм.  
Та \$MNFT койны эзэмшигч болсоноор дараах зүйлсийг хийх боломжтой болно:

## I. \$MNFT койноор NFT худалдаж авах ба зарах

MongolNFT дээр зөвхөн төгрөгөөр бус, \$MNFT койноор гүйлгээ хийх боломж

## II. удахгүй танилцуулагдах Mongolnft стрийминг платформ руу хандах эрх

MongolNFT стрийминг платформ руу хандах токеныг NFT байдлаар зөвхөн \$MNFT койноор худалдан авч, зарим контентыг үзэх эрх

## III. гуравдагч этгээдтэй интеграци хийх

Дэлхийн томоохон стрийминг болон тоглоомын үйлчилгээ үзүүлдэг платформууд руу \$MNFT койноор худалдан авсан эрхээр хандах боломж

## IV. Metaverse дээрх хөрөнгө оруулалт

Бид дэлхийн томоохон MetaVerse платформууд дээр хөрөнгө оруулж, виртуал газар худалдан авахаар төлөвлөж байгаа бөгөөд ингэснээрээ Монголынхоо уран бүтээлчдийг дэлхийд таниулах гүүр болоод зогсохгүй газрын төлбөр болон шимтгэлийг \$MNFT-ээр төлөх боломжтой болох юм.

## V. NFT тоглоом (байх боломжтой)

Ирээдүйдээ бид өөрсдийн NFT тоглоомыг бий болгохоор төлөвлөж байгаа бөгөөд ингэснээрээ уламжлалт тоглоомын дизайныг шинэ механизмуудтай холбон, тоглоом дотроо \$MNFT койноор худалдан авах боломжтой дүр, нүүр царай, зэвсэг, виртуал газар гэх мэт зүйлсийг оруулах боломжтой юм.

# КОЙНЫ ХУВААРИЛАЛТ




# ХУВААРИЛАЛТ

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

АНГИЛАЛ	ҮНЭ
Тэмдэглэгээ	MNFT
Нийт койны тоо ширхэг	400'000'000'000
Ширхэгийн үнэ (Төгрөг)	0.3
Нийт үнэ (Төгрөг)	120'000'000'000
Нэг хүн авах лимит	15'000'000

КАТЕГОРИ	ТОКЕН	ХУВЬ
IEO	140,000,000,000.00	35.00%
Маркетинг	20,000,000,000.00	5.00%
Бизнес хөгжүүлэлт болон түншлэл	40,000,000,000.00	10.00%
DeFi буюу төвлөрсөн бус санхүү	20,000,000,000.00	5.00%
Баг, зөвлөхүүд болон ТУЗ-н гишүүд	120,000,000,000.00	30.00%
Компаний нөөц	20,000,000,000	5.00%
LP	40,000,000,000	10.00%
<b>БҮГД</b>	<b>400,000,000,000</b>	<b>100%</b>



- IEO
- МАРКЕТИНГ
- БИЗНЕС ХӨГЖИЛ БА ТҮНШЛЭЛ
- DEFI БУЮУ ТӨВЛӨРСӨН БУС САНХҮҮ
- БАГ, ЗӨВЛӨХҮҮД, БОЛОН ТУЗ-Н ГИШҮҮД
- КОМПАНИЙ НӨӨЦ
- LP

\*НИЙТ АШИГЛАХ ОРЛОГЫН ХЭМЖЭЭ (1 ба 2-р ээлж) - 42'000'000'000 (Төгрөг)

# ОЙРЫН БОЛОН ХЭТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Хэрэглэгчид шинээр бүртгүүлэх болон нэвтрэх боломжтой болов
- Хэрэглэгчид өмнө нь гарсан, одоо байгаа, болон шинээр гарах коллекциудад оролцон, анхны зах зээл дээр худалдан авах боломжтой болов
- Уран бүтээлчид бүтээлээ нээлттэй эсвэл хязгаартай байдлаар анхны зах зээл дээр гаргах боломжтой болов
- Хэрэглэгчид анхны зах зээлээс NFT худалдан авах боломжтой болов

## 1 - 2021 оны 3-р улирал



## 3 - 2021 оны 4-р улирал



## 5 - Тун удахгүй



## 2 - 2021 оны 4-р улирал

- Хэрэглэгчид хэтэвчин дэх төгрөгийн үлдэгдлээ харах боломжтой болов
- Хоёрдогч зах зээл дээр худалдан авалт хийх боломжтой болов
- Хэтэвчнээсээ мөнгөө гаргаж авах боломжтой болов
- \$MNFT койны IEO

- Уран бүтээлчид NFT-ээ анхны зах зээл дээр дуудлага худалдаа болгон зарах боломжтой болно
- Маш хүчтэй хамт олныг үүсгэж, \$MNFT-н захиргааг DAO концепцын дор танилцуулна

- Стрийминг үйлчилгээний танилцуулга
- MongolNFT дээр төгрөгөөр болон крипто валютаар NFT худалдан авах боломжтой болох бөгөөд MongolNFT стрийминг үйлчилгээ рүү нэвтрэх NFT худалдан авах боломж бүрдэнэ

## 4 - 2022 оны 1-р улирал

Decentraland, CryptoVoxel гэх мэт дэлхийн топ 3-т ордог MetaVerse-үүдэд хөрөнгө оруулж, Монголын уран бүтээлчид бүтээл тавих шимтгэлээ \$MNFT койноор төлөх боломж бүрдүүлнэ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Дэлхий даяар тархсан хэрэглэгчдийг татахын тулд хийх стратегийн хөрөнгө оруулалтууд (Олон улсад болон дотооддоо) хийх
- Massive Adaption of all the artists and creators of Mongolia
- Олон улсын хэрэглэгчдийг татах зорилготой кампанит ажлууд

## 7 - Тун удахгүй

- MongoINFT-н тоглоомын платформ дээрх NFT зөвхөн MNFT-ээр зарагддаг болно
- MongoINFT-н тоглоомын платформ дээрх тоглоомуудын валют MNFT байна
- Тоглоомын зах зээлүүд дээр MNFT-р арилжаалдаг болно

## 9 - Тун удахгүй

## 6 - Тун удахгүй

- Хэрэглэгчид бие бие рүүгээ NFT бэлэглэх боломж
- MongoINFT-ээс бусад NFT платформууд руу, бусад платформуудаас MongoINFT рүү өөрийн NFT-ээ шилжүүлэх боломж
- NFT DeFi буюу төвлөрсөн бус санхүү
- Шинэ төлбөрийн хэрэгслүүд

## 8 - Тун удахгүй

- CryptoPunks, BoredApes, StonerCats гэх мэт ховор цуглуулгууд
- Монголын үндэсний урлагийг модерн урлаг болон криптотой хослуулан гаргах
- Дэлхийн томоохон платформууд болох OpenSea, Foundation дээр гаргаж, маркетинг хийх

# МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид MongolNFT-г дэлхийн хэмжээнд таниулахын тулд тасралтгүй ажилласаар байна.

## Е-спорт багуудын ивээн тэтгэгч

2021 оны 3-р улирлаас эхлэн, бид Монголын томоохон CS:GO баг болох "Checkmate" шиг е-спорт багуудыг ивээн тэтгэж эхэлсэн байгаа.

## Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах боломж

Хэд хэдэн музейн тусламжтайгаар бид соёлын өв, олдворуудыг дижитал болгон, NFT байдлаар дэлхий даяар амьдарч буй Монголын түүх, соёлыг сонирхогчдод сурталчлан, таниулахаар төлөвлөж байна.

## Дэлхийн томоохон NFT төслүүдэд хөрөнгө оруулалт

2022 оны эхний хагасаас эхлэн бид дэлхийн томоохон NFT коллекциудад хөрөнгө оруулахаар төлөвлөж байгаа бөгөөд эдгээр NFT-г эзэмшсэнээр шинэ хүрээлэлд орж, шинэ маркетингийн стратеги гаргах боломжтой гэж харж байгаа.

## 2021 оны 4-р улирал



## 2022 оны 2-р улирал

## 2022 оны 4-р улирал

## 2022 оны 1-р улирал

### Гадаадад байгаа хувцас загварын дизайнерууд, уран бүтээлчидтэй үүсгэсэн түншлэлүүд

Германд аж төрөн, ажиллаж буй хувцас загварын дизайнер Номин-Эрдэнэ болон дижитал уран бүтээлч Ган-Эрдэнэ нар олон жилийн фенүүд, дагагчдаа MongolNFT зах зээл рүү татан ажиллаж байгаа.

## 2022 оны 3-р улирал

### Дэлхийн томоохон NFT төслүүдэд хөрөнгө оруулалт

2022 оны эхний хагасаас эхлэн бид дэлхийн томоохон NFT коллекциудад хөрөнгө оруулахаар төлөвлөж байгаа бөгөөд эдгээр NFT-г эзэмшсэнээр шинэ хүрээлэлд орж, шинэ маркетингийн стратеги гаргах боломжтой гэж харж байгаа.

# МАНАЙ БАГ, ХАМТ ОЛОН



# МАНАЙ БАГ



**АДЪЯА**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ БА  
ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ



**ИТГЭЛ ГАНБОЛД**

ТЕХНОЛОГИ ХАРИУЦСАН  
ЗАХИРАЛ БА ҮҮСГЭН  
БАЙГУУЛАГЧ



**САБИТ БАЗАР**

МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН  
ЗАХИРАЛ БА MONGOLNFT  
БОЛОН INFINITE SOLUTIONS  
КОМПАНИУДЫН ҮҮСГЭН  
БАЙГУУЛАГЧ



**INFINITE SOLUTIONS**

ТЕХНОЛОГИ БА  
МЕНЕЖМЕНТИЙН ТҮНШ



**ҮНЭНБҮРЭН ӨЛЗИЙБҮРЭН**

DEFI ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

# ЗӨВЛӨХҮҮД



**БИЛЛ ШИХАРА**  
BITTREX, COIN HUNT WORLD  
КОМПАНИУДЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ БА ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ




**ОКО ДАВААСҮРЭН**  
TECHSTARS КОМПАНИЙ  
АХЛАХ ЗАХИРАЛ



**БАТТУШИГ БАТСҮРЭН**  
DV&GTS LLP КОМПАНИЙ  
ПАРТНЕР



**ЖОРДАН КЛИФФОРД**  
SCALAR CAPITAL-Н ҮҮСГЭН  
БАЙГУУЛАГЧ  
COINBASE-Д ИНЖЕНЕР БАЙСАН



**ХАТАНБҮҮВЭЙ МӨНХТӨР**  
NFT МЭРГЭЖИЛТЭН

# ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД



# ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛҮҮД



## ТАЙЛБАР, АНХААРУУЛГА БОЛОН ЭРСДЭЛ

ТА MNFT КОЙНД ХӨРӨНГӨ ОРУУЛАХАД ЗАРЦУУЛСАН БҮХИЙ Л МӨНГӨӨ АЛДАЖ БОЛЗОШГҮЙГ АНХААРНА УУ. ХЭРЭВ ТА MNFT КОЙНД ХӨРӨНГӨ ОРУУЛСАН БҮЮУ ХУДАЛДАН АВСАН БОЛ БИД ТАНЫ МӨНГИЙГ БУЦААН ОЛГОХ БҮЮУ ХУДАЛДАНАВАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОМЖГҮЙ БОЛОХЫГ МЭДЭГДЭЖ БАЙНА.

ТА ЭНЭХҮҮ ВАЙТПЭЙПЕРТ (WHITEPAPER) ТУСГАГДСАН НӨХЦӨЛҮҮДИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСНӨӨР ХУУЛИАР ЗӨВШӨӨРСӨН ХЭМЖЭЭ ХЯЗГААРЫН ХҮРЭЭНД ӨӨРТ ОЛГОГДСОН ЭРХЭЭСЭЭ ТАТГАЛЗАЖ БАЙГААГ АНХААРНА УУ. ӨӨРӨӨР ХЭЛБЭЛ, ТАМNFT КОЙНЫ АРИЛЖААНД ОРОЛЦСОН БОЛ MNFT КОЙН АРИЛЖАА ЭСХҮЛ ЭНЭХҮҮ ВАЙТПЭЙПЕРТ ТУСГАГДСАН ТӨСӨЛ НЬ ХҮЛЭЭЛТИЙН ДАГУУ БИЕЛЭГДЭЭГҮЙ БҮЮУ БҮРЭН АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД ТАНЫГ КОМПАНИАС НӨХӨН ТӨЛБӨР ЭСХҮЛ ӨӨРТ УЧИРСАН ХОХИРЛОО ШААРДАХ, КОМПАНИЙН ЭСРЭГ НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЗЭРЭГ КОМПАНИЙН ЭСРЭГ АЛИВАА ҮЙЛДЭЛ ХИЙХ ЭРХЭЭСЭЭС ТАТГАЛЗАЖ БАЙГАА ГЭЖ ҮЗНЭ.

ХЭРЭВ ТА ЭНЭХҮҮ ВАЙТПЭЙПЕРТ ЗААГДСАН АЛИВАА НЭГ АСУУДЛААР ЭРГЭЛЗЭЭ ТӨРСӨН ЭСХҮЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААС ШАЛТГААЛАН ХӨРӨНГӨ ОРУУЛСАН МӨНГӨӨ АЛДАХ НЬ ТАНЫ ХУВЬД САНХҮҮГИЙН ӨНДӨР ЭРСДЭЛ ДАГУУЛАХААР БОЛ БИДНИЙ ЗҮГЭЭС ТАНД MNFT КОЙНЫГ ХУДАЛДАН АВАХГҮЙ БАЙХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

ТА ЭНЭХҮҮ ВАЙТПЭЙПЕРТ ТУСГАСАН MNFT КОЙНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХООСОО ӨМНӨ MNFT КОЙНЫ ХУДАЛДАН АВАЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУДЫН ТАЛААР ХУУЛЬ, САНХҮҮ, ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ БОЛОН БУСАД МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ ЗӨВЛӨЛДӨХИЙГ БИДНИЙ ЗҮГЭЭС ТАНД ЗӨВЛӨЖ БАЙНА.

MNFT КОЙН НЬ ЯМАРВАА ТӨРЛИЙН ХУВЬЦАА ЭСХҮЛ ҮНЭТ ЦААСТАЙ ДҮЙЦЭХҮЙЦ БҮТЭЭГДЭХҮҮН БИШ. МӨН ТАНЫ ХУДАЛДАН АВСАН КОЙНУУД НЬ КОМПАНИЙГ ӨМЧЛӨХ ЭСХҮЛ ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ БУСАД ЭРХИЙГ НОТЛОХГҮЙ БӨГӨӨД ТАНЫ ХУДАЛДАН АВСАН КОЙНУУД НЬ ЗӨВХӨН ЭНЭХҮҮ ВАЙТПЭЙПЕРТ ТУСГАСАН ТОДОРХОЙ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЭРХТЭЙ БОЛОХЫГ Л НОТолно. MNFT КОЙН НЬ АЛИВАА НЭГЭН ТӨРИЙН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛД АЛБАН ЁСООР БҮРТГЭГДЭЭГҮЙ БҮЮУ БҮРТГЭЛЭЭС ЧӨЛӨӨЛӨГДӨӨГҮЙГЭЭС ГАДНА ОДООГИЙН БАЙДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД БҮРТГҮҮЛЭХ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ, ТЭДГЭЭР ҮҮРГЭЭС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ТАЛААР ЯМАРВАА НЭГЭН ТӨЛӨВЛӨГӨӨ ЭСХҮЛ ҮЙЛДЭЛ ХИЙГЭЭГҮЙ БОЛНО. ЭНЭХҮҮ ВАЙТПЭЙПЕР НЬ ЯМАР НЭГЭН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ЭСХҮЛ ТҮҮНИЙГ САНАЛ БОЛГОСОН БАРИМТ БИЧИГ БИШ БӨГӨӨД ҮҮНД АГУУЛАГДСАН МЭДЭЭЛЭЛ НЬ АЛИВАА НЭГЭН ОРНЫ ҮНЭТ ЦААСНЫ БҮЮУ ҮНЭТ ЦААСААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХИЙГ САНАЛ БОЛГОХ ЗОРИУЛАЛТГҮЙ БОЛНО.

“Тайлбар, Анхааруулга болон Эрсдэл”-ийн тухай бүлгийг АНХААРАЛТАЙ УНШИХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү Вайтпэйперт тусгагдсан койны арилжаа (“MNFT Койны худалдаа” эсхүл MNFT Койны арилжаа)-нд оролцохдоо “Тайлбар, Анхааруулга болон Эрсдэл”-ийн тухай бүлгийг бүрэн уншсан байх ёстой болохыг анхаарна уу.

“Тайлбар, Анхааруулга болон Эрсдэл”-ийн тухай хэсэг нь энэхүү Вайтпейпер болон Компанийн цахим хуудсанд байршсан нийтэд нээлттэй аливаа мэдээлэлд хамаарна. “Тайлбар, Анхааруулга болон Эрсдэл”-ийн тухай хэсгийн агуулга нь (i) энэхүү Вайтпэйперийг хэрэглэх, (ii) энэхүү Вайтпэйпер болон MNFT Койны худалдаатай холбогдуулан бидний зүгээс тухай бүр нийтэлсэн, ил болгосон аливаа бусад нөхцөл, болзлуудад өөрчлөлт оруулах, болон (iii) Койны арилжаатай холбоотой эрсдэл болон тодорхойгүй байдалд хамааралтай болно. “Тайлбар, Анхааруулга болон Эрсдэл”-ийн тухай бүлэг шинэчлэгдэх буюу өөрчлөгдөж болох бөгөөд энэхүү шинэчлэгдсэн бүлэг нь Вайтпэйперийн сүүлийн хувилбарын хамт Компанийн цахим хуудсанд нийтлэгдэх болно. Та MNFT Койны арилжаанд оролцохоосоо өмнө Компанийн цахим хуудсанд байршуулсан Вайтпэйперийн сүүлийн хувилбартай танилцаж, бүрэн уншина уу.

“Тайлбар, Анхааруулга болон Эрсдэл”-ийн тухай бүлэгт тусгагдсан мэдээлэл нь бүхнийг хамрах боломжгүй бөгөөд гэрээний харилцаа үүсгэх урьдач нөхцөлийг агуулаагүй болно. MNFT Койны арилжаанд оролцохоор төлөвлөж буй этгээд нь арилжаанд оролцохоосоо өмнө мэргэжлийн хараат бус зөвлөхийн зөвлөгөөг авахыг бидний зүгээс хүсэж байна.

Хэрэв “Тайлбар, Анхааруулга болон Эрсдэл ”-ийн тухай бүлэг бүхэлдээ эсхүл хэсэгчлэн хүчин төгөлдөр бусад тооцогдох, хууль бус болох эсхүл хэрэгжүүлэх боломжгүй болох тохиолдолд энэхүү бүлгийг хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байлгах эсхүл хэрэгжилтийг хангахын тулд боломжит хэмжээгээр өөрчлөлт оруулж болно. Өөрчлөлт оруулах боломжгүй тохиолдолд хүчин төгөлдөр бус эсхүл хууль бусад тооцогдсон холбогдох нөхцөл, заалтыг хүчингүй болсонд тооцно. Энэхүү өөрчлөлт болон бүлгийн аль нэг хэсгийг өөрчилсөн эсхүл хүчингүй болгосон нь “Тайлбар, Анхааруулга болон Эрсдэл”-ийн тухай бүлгийн бусад хэсгүүдийн хуулийн хүчин төгөлдөр байдал болон хэрэгжилтэд нөлөөлөхгүй болно.

## ТАЙЛБАР, АНХААРУУЛГА

Энэхүү Вайтпэйпер нь зөвхөн мэдээлэл олгоход зориулагдсан болно. MNFT Койны арилжаанд оролцох хүсэлтэй хүн бүр худалдан авалт хийх, арилжаанд оролцох шийдвэр гаргахаасаа өмнө арилжаанаас үүсэх бүхий л төрлийн эрсдэлийг харгалзан үзэхийг Компанийн зүгээс зөвлөж байна. Энэхүү Вайтпэйперт агуулагдсан мэдээлэл нь Компани, Компанийн төлөөлөгчдийн зүгээс өгсөн зөвлөгөө эсхүл энэхүү Вайтпэйперийг хэрэглэж буй хүн бүрт Койны арилжаатай холбоотой ямарваа нэгэн зөвлөгөө, зөвлөмж өгч буй хэлбэр биш юм. Энэхүү Вайтпэйперт тусгагдсан мэдээлэл нь Компани, MNFT Койн, түүний арилжаа, цаашдын ирээдүйн үйл ажиллагаа зэрэгтэй холбоотой бүхий л эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлоогүй, буюу тодорхойлохыг завдаагүй болно. Хэрэв танд энэхүү Вайтпэйперийн аль нэг бүлэг, хэсэг эргэлзээ төрүүлсэн бол бие даан судлах буюу мэргэжлийн хараат бус зөвлөхөөс зөвлөгөө авсны дараа арилжаанд оролцох эсэх талаар өөрийн бие даасан дүгнэлтийг гаргана уу. MNFT Койны арилжаанд оролцогч нь өөрийн хөрөнгө оруулалт, нягтлан бодох бүртгэл, хууль болон татварын асуудлаарх мэргэжлийн зөвлөх болон Компани, MNFT Койн, түүний арилжаа, цаашдын үйл ажиллагаа эсхүл Койны хэрэглээний талаар холбогдох бусад мэргэжлийн зөвлөхөд хандах, түүнтэй тогтмол зөвлөлдөх ба MNFT Койны худалдан авалтын зохимжит үе, үр дагавар, санхүүгийн эрсдэлийг ялгаж салгах нь зүйтэй.

MNFT Койныг худалдан авах нь ихээхэн эрсдэлтэй байж болзошгүй бөгөөд MNFT Койны хөрөнгө оруулалтад зарцуулсан бүхий л мөнгөө эсхүл түүний нилээдгүй хэсгийг алдах зэрэг онцгой эрсдэл учруулах бүрэн боломжтой. MNFT Койны арилжаанд оролцогчид нь Компани, MNFT Койн, түүний арилжаа, цаашдын үйл ажиллагаа болон MNFT Койны хэрэглээний онцлог шинж чанарыг бүрэн ойлгож, ухамсарласан байхыг бидний зүгээс зөвлөж байна. Хэрэв та энэхүү Вайтпэйперт заасан нөхцөлүүдийг бүхэлд нь хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл MNFT КОЙНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХООС ТАТГАЛЗАХЫГ ЗӨВЛӨЕ. Энэхүү Вайтпэйпер бүхэлдээ эсхүл түүний зарим бүлэг, хэсэгт тусгагдсан Компанийн төсөл, зорилт эсхүл үр дүн нь бодитоор бүрэн буюу тодорхой хэмжээнд биелэгдэнэ гэсэн баталгаа эсхүл нотолгоог Компани, Компанийн төлөөлөгчдийн зүгээс гаргаагүй болно. Та өөрийн хувийн болон санхүүгийн нөхцөл байдал, санхүүгийн эх үүсвэрийг харгалзан MNFT Койны арилжаанд оролцох талаар шийдвэрээ гаргана уу.

## АЛБАН ЁСНЫ БҮРТГЭЛГҮЙ БАЙДАЛ БОЛОН ҮНЭТ ЦААС САНАЛ БОЛГООГҮЙ ТУХАЙ

Энэхүү Вайтпэйпер нь ямар нэгэн үнэт цаасны танилцуулга эсхүл түүнийг санал болгосон баримт бичиг биш бөгөөд үүнд агуулагдсан мэдээлэл нь аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаасны буюу үнэт цаасаар хөрөнгө оруулалт хийхийг санал болгоогүй болно. Энэхүү Вайтпэйпер нь бүхэлдээ эсхүл түүний аль нэг хэсэг нь гэрээ байгуулах эсхүл ямарваа нэгэн хуулийн хүрээнд бий болох үүргийг хэн нэгэнд оногдуулаагүй бөгөөд энэхүү Вайтпэйперийг криптовалют эсхүл түүнтэй адилтгах төлбөрийн хэрэгслийг хүлээн зөвшөөрөх үндэслэл гэж үзэж болохгүй. MNFT Койныг худалдах, худалдан авах үйл ажиллагаа нь дан ганц MNFT Койныг худалдах, худалдах авах гэрээний нөхцөл, заалтуудын дагуу зохицуулагдах бөгөөд өөр бусад баримт бичгээр зохицуулагдахгүй. Хэрэв MNFT Койн худалдах, худалдан авах гэрээ болон энэхүү Вайтпэйперийн нөхцөл, шаардлагууд зөрчилдвөл, худалдах худалдан авах гэрээнд тусгагдсан нөхцөл, болзлуудыг дагаж мөрдөнө.

Хэрэв та ямарваа нэгэн олон улсын байгууллагын хориг арга хэмжээ тавигдсан улсын иргэн, оршин суугч (татварын болон бусад зорилгоор), эсхүл тухайн улсын ногоон карт (Green card) эзэмшигч эсхүл хориг арга хэмжээ тавигдсан этгээд бол MNFT Койны арилжаанд оролцох эрхгүй. Төрийн ямарваа нэгэн эрх бүхий зохицуулагч байгууллага, албан тушаалтан энэхүү Вайтпэйперийг хянаж, зөвшөөрөл олгоогүй болно. Аливаа хууль тогтоомж, зохицуулалтын баримт бичиг, дүрэм журмын дагуу дээрхтэй адил арга хэмжээ авсан буюу авсан байхыг цаашид шаардахгй болно. Энэхүү Вайтпэйперийг нийтэд ил болгож, түгээж байгаа нь энэхүү баримт бичигт холбогдох хууль тогтоомжид нийцсэн болохын илэрхийлэл биш юм.

# ХУУЛЬ ЗҮЙН ХОЛБОГДОЛТОЙ АНХААРУУЛГА

“Мултимедиа Энтертайнмент Платформ” ХХК (“Компани”) нь Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж холбогдох байгууллагад бүртгүүлсэн болно. Монгол Улсын хэмжээнд блокчэйн технологид суурилсан бизнес, үйл ажиллагаа, мөн түүнчлэн криптовалюта болон түүнтэй холбогдох бизнесүүдийн эрх зүйн зохицуулалтын орчин бий болоогүйг Компани харгалзан MNFT Койны арилжааг ил тод, хариуцлагатай, ухаалаг аргаар явуулахын тулд өөрийн боломжит хүчин чармайлтыг гаргасан болно. Компанийн авсан хууль зүйн зөвлөх үйлчилгээ нь зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид үндэслэсэн бөгөөд таны оршин сууж буй улсаас хамааран MNFT Койныг үнэт цаас гэж тодорхойлох эсхүл тус Койныг худалдан авахыг санал болгох нь хуулиар зохицуулагдсан эсхүл хориглосон байх боломжтойг анхаарна уу. Энэ тохиолдолд Компани таны өмнө ямарваа нэгэн үүрэг, хариуцлага хүлээхгүй болно. Таны оршин сууж буй улсын хууль тогтоомжид MNFT Койны арилжаанд оролцох, худалдан авахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын талаар мэргэжлийн хараат бус хуулийн зөвлөхөөс хууль зүйн зөвлөгөө авахыг зөвлөж байна.

Хэдийгээр Монгол Улсаас гадна дэлхий даяар блокчэйн технологи болон токены арилжааны эрх зүйн орчин хараахан бүрдээгүй ч Компани нь ямарваа нэгэн зохицуулалтын арга хэмжээ бий болсон тохиолдолд түүнийг дагаж мөрдөхийн тулд өөрийн хэмжээнд боломжит арилжааны аргуудыг ашиглах болно. MNFT Койн нь үнэт цаас, түүгээр гэрчлэгдэх эрхийг нотлохгүй болно. Хэрэв та MNFT Койныг худалдан авсан бол таны худалдан авалтыг буцаах буюу мөнгийг эргүүлэн олгох эсхүл өөрчлөх боломжгүй. Спекулятив буюу эрсдэлтэй хөрөнгө оруулалтын зорилгоор буюу богино хугацаанд их хэмжээний ашиг олох зорилгоор MNFT Койнд хөрөнгө оруулалт хийхгүй байхыг танд зөвлөж байна. MNFT Койн нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу Компани, түүний хамаарал бүхий Компанийн хөрөнгө, засаглал, Компанийн удирдлагын түвшний асуудалд оролцон санал өгөх эсхүл түүнтэй адилтгах бусад эрхийг гэрчлэхгүй болно. Хэрэв та криптографик токен, блокчэйн суурилсан технологийн талаар мэдлэг, туршлагагүй, эсхүл хараат бус мэргэжлийн зөвлөхөөс зөвлөгөө аваагүй бол MNFT Койныг худалдан авахгүй байхыг Компанийн зүгээс танд зөвлөж байна

Компани өөрийн сонгосон өөр бусад хэл дээр энэхүү Вайтпэйпер, түүнд тусгасан мэдээллийг хөрвүүлж болно. Хэрэв Англи хэл дээрх хувилбар болон өөр бусад хэл дээрх хувилбар хоорондоо зөрчилдвөл, Англи хэл дээрх хувилбарыг дагаж мөрдөнө.

MNFT Койн нь аливаа эрх зүйн харьяалал, хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаас буюу үнэт цаасаар гэрчлэгдэх эрх биш бөгөөд үнэт цаас, түүгээр гэрчлэгдэх эрх бий болох үндэслэл болохгүй. Энэхүү Вайтпэйпер нь ямар нэгэн төрлийн хөтөлбөр эсхүл аливаа үйлдлийг уриалсан баримт бичиг биш бөгөөд аливаа улс орны хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаасны буюу үнэт цаасаар хөрөнгө оруулалт хийхийг санал болгосон баримт бичиг биш юм. Компани MNFT Койныг худалдан авах, худалдах, эсхүл бусад байдлаар шилжүүлэх талаар ямарваа нэгэн зөвлөмж, зөвлөгөөг өгөөгүй бөгөөд энэхүү Вайтпэйперийг бүхэлд нь эсхүл зарим бүлэг хэсгийг нийтэд ил тод байдлаар нийтэлсэн, хүргүүлсэн нь ямарваа нэгэн гэрээ байгуулах эсхүл хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үндэслэл болохгүй болно

## ЗӨВЛӨГӨӨ, ЗӨВЛӨМЖ АГУУЛААГҮЙ

Энэхүү Вайтпэйперт тусгагдсан мэдээлэл нь Компани, MNFT Койн, түүний ирээдүйн арилжаа, Вайтпэйпертэй холбогдон үүсэх асуудлаарх бизнесийн, санхүүгийн, хууль зүйн болон татварын ямарваа зөвлөгөө, зөвлөмжийг агуулаагүй. Та энэхүү Вайтпэйпертэй хамааралтай асуудлаар өөрийн санхүүгийн, хуулийн, татварын болон бусад мэргэжлийн хараат бус зөвлөхтэй зөвлөлдөнө үү. Та MNFT Койныг худалдан авснаас үүдэх аливаа санхүүгийн эрсдэлийг тодорхойгүй хугацаагаар хариуцах болно.

# ХАРИУЦЛАГЫН ХЯЗГААРЛАЛТ

Дараах үйлдэл, нөхцөл байдал зэргээс үүдэлтэй, эсхүл үүдэн гарсан токен худалдан авагчийн алдагдал, хохирол, алдагдсан хадгаламж, санамсаргүйгээр үүссэн шууд болон шууд бус, тусгай болон үр дагаварт учирсан хохирлын төлбөрийг ямар ч тохиолдолд Компани болон Компанийн одоогийн болон өмнөх ажилтан, эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, түнш, итгэмжлэгдсэн төлөөлөгч, агент, төлөөлөгч, зөвлөх, гэрээлэгчид болон сайн дурын ажилтнууд (цаашид "Компанийн төлөөлөгчид" гэх) хариуцахгүй:

- Компани болон түүний хамаарал бүхий Компанийн энэхүү Вайтпэйперт тодорхойлсон, төлөвлөгдсөн MNFT Койны шинж чанар, төсөл, платформын зарим хэсэг эсхүл бүхэлдээ бодитой, бүрэн дүүрэн хэрэгжээгүйгээс үүдэлтэй;
- Компанийн зүгээс санал болгосон аливаа үйлчилгээ, бүтээгдэхүүн, платформ, гишүүнчлэлийн сүлжээ болон MNFT Койныг хэрэглэгчийн зүгээс ашигласан, эсхүл ашиглаж чадаагүйгээс үүдэлтэй;
- Компани, Компанийн төлөөлөгчид, хэрэглэгч, та болон аливаа гуравдагч этгээд эдгээр нөхцөлүүдийн аль нэгийг зөрчсөнөөс үүдэлтэй;
- Аливаа аюулгүй байдлын эрсдэл, зөрчил, заналхийлэл, халдлага, хулгай, гадны халдлага, нууц үгээ алдах, хувийн түлхүүрээ алдах болон эдгээртэй төстэй нөхцөлийн улмаас мэдээлэл алдах зэргээс үүдэлтэй;
- MNFT Койны арилжаанд хамаарах код, бичвэр, зураг болон Вайтпэйперт тусгагдсан аливаа мэдээллийн алдаа, доголдлоос үүдэлтэй;
- Вайтпэйперт тусгагдсан эсхүл орхигдсон аливаа мэдээллээс үүдэлтэй;
- Вайтпэйперээс үүсэлтэй /эсхүл үүссэн гэж үзэж байгаа/ аливаа амлалт, мэдэгдэл, баталгаанаас үүдэлтэй;
- Аль нэг улс орон эсхүл аль нэг бирж, зах зээл /зохицуулалттай, зохицуулалтгүй, анхдагч, хоёрдогч гэх мэт бусад бүх зах зээлийг хамааруулан/ дээрх MNFT Койны үнийн хэлбэлзлээс үүдэлтэй;
- MNFT Койныг худалдан авах, ашиглах, зарах, дахин зарах, эргүүлэн авах болон бусад хэлбэрээр арилжихтай холбогдон үүссэн;
- MNFT Койны арилжаа явагдаж буй аливаа бирж, зах зээл /зохицуулалттай, зохицуулалтгүй, анхдагч, хоёрдогч гэх мэт бусад бүх зах зээлийг хамааруулан/ дээрх аливаа доголдлоос үүдэлтэй;

- Зах зээлийн хэвийн бус хэмжээний эрэлтийн улмаас MNFT Койныг худалдан авах үед хэрэглэгчийн захиалга биелэгдээгүйгээс үүдэлтэй;
- Хэрэглэгч өөрийн MNFT Койн хадгалагдаж буй хэтэвч /wallet/-ийн хувийн түлхүүрийг зохих ёсоор хадгалж, баталгаажуулаагүйгээс үүдэлтэй, /хамтад нь "Хариуцлагын хүрээнээс гадуурх асуудлууд" гэх/.

Энэхүү Вайтпэйпер болон MNFT Койн нь бодит болон зөвшилцмөл байдлаар аливаа мэдэгдэл болон ямар ч төрлийн баталгаагүйгээр зөвхөн MNFT Койныг "байгаагаар нь" худалдан авагчид буюу арилжаанд оролцогчид хүргэж байгаа болно. Худалдан авагч нь энэхүү Вайтпэйперт тусгасан мэдээллийг ашиглан MNFT Койныг худалдан авах, ашиглахтай холбогдсон бүхий л хариуцлага, эрсдэлийг хүлээнэ. Холбогдох хууль тогтоомжоор дээрх Хариуцлагын хүрээнээс гадуурх асуудлуудыг бүхэлд нь эсхүл хэсэгчилсэн байдлаар хориглосон тохиолдолд хязгаарлалт хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд худалдан авагчид үйлчилнэ. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээгээр худалдан авагч нь (i) Компани, Компанийн төлөөлөгчдийн эсрэг эсрэг гаргаж болох төлбөр болон нөхөн төлбөр, эргэн төлөлт гэх мэт болон Хариуцлагын хүрээнээс гадуурх асуудлуудтай холбоотой бүх төрлийн аливаа нэхэмжлэл шаардлага /бодитоор эсхүл гаргах боломжтой эсэхээс үл хамааран ажилтан, эрх бүхий албан тушаалтан, итгэмжлэгдсэн төлөөлөгч, агент, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, болон бусад этгээдийн эсрэг ямар ч тохиолдолд, ямар хэлбэрээр үүссэнээс үл шалтгаалан/ гаргах эрхээсээ үүгээр татгалзаж байгаа ба (ii) Компани, Компанийн төлөөлөгчдийг худалдан авагчийн өмнө хүлээх хариуцлагаас /ямар шинж чанартай, яаж үүссэнээс үл шалтгаалан/ эргэлт буцалтгүйгээр, ямарваа болзолгүйгээр бүрэн чөлөөлсөн болно.

Энэ хэсэг болон эдгээр нөхцөлийн дагуу чөлөөлөгдсөн, татгалзсан болсон аливаа нэхэмжлэлийн хувьд ямар нэг шалтгаанаар арга хэмжээ авах болон хуулийн дагуу үйлдэл хийх эсхүл Компани, Компанийн төлөөлөгчдийн эсрэг нэхэмжлэл гаргахыг оролдох тохиолдолд ийнхүү нэхэмжлэл гаргасан, үйлдэл хийсэн тохиолдол бүрт дараах шаардлагын дагуу Компани болон Компанийн төлөөлөгчдэд учирсан хохирлыг барагдуулж, нөхөн төлбөр төлөхийг худалдан авагч хүлээн зөвшөөрч байна:

- Компани, Компанийн төлөөлөгчдэд учирсан бүхий л хариуцлага болон хохирол;
- Компани, Компанийн төлөөлөгчдийн зүгээс гаргасан бүхий л өртөг, хураамж, зардал /хуулийн үйлчилгээ авахтай холбогдсон бүхий л зардал, хураамжийг оролцуулан/.

# МЭДЭГДЭЛ БОЛОН БАТАЛГАА ГАРГАХГҮЙ

Вайтпэйперт шууд болон шууд бус хэлбэрээр тусгагдсан аливаа заалт, нөхцөл бусад мэдэгдлээс үл хамааран, Компани нь аливаа хүн, хуулийн этгээдийн өмнө Вайтпэйперт тусгагдсан мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлын талаар болон аливаа бусад төрлийн мэдэгдэл, баталгаа гаргаагүй, үүрэг хүлээгээгүй буюу мэдэгдэл, баталгаа гаргах болон ямарваа үүрэг хүлээх талаар илэрхийлээгүй болно.

# MNFT КОЙН ХУДАЛДАН АВАГЧИЙН МЭДЭГДЭЛ БОЛОН БАТАЛГАА

Вайтпэйперт өгөгдсөн мэдээллийг хэрхэн яаж гэдгээс үл хамааран бүхэлд нь эсхүл зарим хэсгийг олж авах буюу эзэмших болон харилцахыг хүлээн зөвшөөрснөөр олж авсан өдөр эсхүл Вайтпэйпер дахь мэдээлэл бүхэлдээ буюу зарим хэсэг нь таны эзэмшилд шилжсэн сүүлийн өдрөөр худалдан авагч нь дараах мэдэгдэл, баталгааг гаргасан /эсхүл гаргах ёстой гэж үзнэ:

- 18 /арван найм/ нас хүрсэн;
- MNFT Койн нь ямарваа эрх зүйн харьяалал, улс орны хууль тогтоомжийн хүрээнд ямар нэг хувьцаа, бонд, үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл болон хөрөнгө оруулалт биш болохыг хүлээн зөвшөөрч;
- Вайтпэйперт өгөгдсөн мэдээллийн үндсэн дээр энэхүү тусгагдсан мэдээлэл нь үнэт цаасны танилцуулга эсхүл санал болгож буй баримт бичиг биш бөгөөд үнэт цаас санал болгох замаар гэрээ байгуулах урьдач нөхцөл, заавал биелүүлэх шаардлагатай хууль зүйн үүрэг үүсгэхгүйн дээр криптовалюта зэрэг төлбөрийн бусад хэлбэр биш болохыг хүлээн зөвшөөрсөн;

- Энэхүү Вайтпэйперийг ямар ч зохицуулалтын байгууллага шалгаагүй буюу хуулийн дагуу ямар нэг үйлдэл хийгдээгүй бөгөөд аливаа хууль, эрх зүйн зохицуулалтын шаардлага, дүрэм, Вайтпэйперт өгөгдсөн мэдээллийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нийтлэх, түгээх нь холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлага, дүрмийг дагаж мөрдсөнийг батлахгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байна;

- Вайтпэйперт өгөгдсөн мэдээлэл, MNFT Койн худалдаалах үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл болон ирээдүйд MNFT Койныг аливаа бирж, зах зээл /зохицуулалттай, зохицуулалтгүй, анхдагч, хоёрдогч гэх мэт бусад бүх зах зээлийг хамааруулан/ дээр арилжаалахыг Компани, MNFT, MNFT Койн, болон энэхүү Вайтпэйперийн ололт амжилт гэж үзэхгүй;

- Вайтпэйпер, түүний аль нэг хэсэг, хуулбарыг тараах, түгээх, хүлээн авах нь таны оршин суугаа газрын эсхүл харьяалах хууль тогтоомж, дүрэм, журмаар хориглоогүй, хязгаарлаагүй, эзэмшилтэй холбоотой аливаа хязгаарлалт үйлчилж байгаа тохиолдолд худалдан авагч эдгээр хязгаарлалтуудыг өөрийн зардлаар Компанид аливаа хариуцлага хүлээлгэхгүйгээр дагаж мөрдөнө;

- MNFT Койныг худалдан авахыг хүсэж байгаа тохиолдолд MNFT Койныг дараах байдлаар тайлбарлах, ангилал, хэрэглэх ёсгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байна

- аливаа төрлийн валют, бараа бүтээгдэхүүн;
- аливаа этгээд, аж ахуйн нэгжийн гаргасан өр төлбөр, хувьцаа (Компани болон бусад тохиолдолд);
- өрийн бичиг, хувьцаа, хувьцааны эрх, опцион, дериватив;
- ашиг олох, алдагдлаас зайлсхийх зорилго, дүр эсгэсэн зорилго бүхий ялгаатай гэрээ болон бусад гэрээний дагуу үүсэх эрх;
- хамтын хөрөнгө оруулалтын схем дэх нэгжүүд;
- бизнесийн итгэлцлийн нэгжүүд;
- бизнесийн итгэлцлийн нэгжийн дериватив;
- бусад үнэт цаас эсхүл үнэт цаасны ангилал

- Хэрэв MNFT Койн худалдан авахыг хүсэгч нь хориг арга хэмжээ авагдсан улсын иргэн, үндэстэн, оршин суугч /татварын болон бусад зорилгоор/, ногоон карт эзэмшигч эсхүл хориг арга хэмжээ авагдсан этгээд байх тохиолдолд MNFT Койн худалдан авах эсхүл Вайтпэйперт хандах эрхгүй гэдгээ бүрэн дүүрэн ойлгож, мэдэж байгаа;

- Та криптовалютын ажиллагаа, ашиглалт, хадгалалт, дамжуулах механизм болон бусад материаллаг шинж чанар, блокчэйнд суурилсан програм хангамжийн систем, криптовалютын түрийвч /wallet/ болон бусад холбогдох токэн хадгалах механизм, блокчейн технологи, ухаалаг гэрээний технологийн талаар ерөнхий ойлголттой;

- MNFT Койныг худалдан авах тохиолдолд: (A) Компанийн болон түүний бизнес үйл ажиллагаа; (B) MNFT Койн; (C) аливаа бирж эсхүл зах зээл /зохицуулалттай, зохицуулалтгүй, анхдагч, хоёрдогч болон бусад/ дээрх MNFT Койны худалдаа; (D) энэхүү Вайтпэйперт бүхэлд нь болон зарим хэсэгт найдан ажиллах зэргээс үүдэлтэй эрсдэлүүд үүсэх боломжтой талаар бүрэн ойлгож, мэдсэн;
- Компани нь шууд болон шууд бус хэвийн бус тохиолдлын шинжтэй, гэм хор, гэрээ болон Вайтпэйпер болон түүний зарим хэсгийг хүлээн зөвшөөрсөн, найдсаны улмаас эсхүл найдсантай холбоотойгоор үүссэн бусад /ашиг, орлогын алдагдал, ашиглалт, мэдээллийн алдагдал, нэр хүндэд учирсан хохирол, бүхий л эдийн хохирол болон алдагдсан боломж зэргээс үүдэлтэй/ асуудалд хариуцлага хүлээхгүй гэдгийг ойлгож хүлээн зөвшөөрсөн;
- Дээрх бүх мэдэгдэл, баталгаа нь Вайтпэйперт сүүлд нэвтэрсэн, Вайтпэйперийг эзэмшсэн /тохиолдолд/ үеэс эхлэн тодорхой бөгөөд үнэн, бүрэн дүүрэн, алдаа мадаггүй болно

## ХЭТИЙН ТӨЛӨВИЙН ТААМАГЛАЛЫН ТАЛААР ӨГӨХ АНХААРУУЛГА

Вайтпэйперт орсон бүх мэдэгдэл, Компани болон Компанийн төлөөлөгч /тодорхой тохиолдолд/ нарын аливаа хэвлэлийн мэдээнд тусгагдсан, олон нийтийн болон аман мэдэгдэл зэрэг нь түүхийн баримтат мэдэгдэл бус “хэтийн төлөвийн таамаглал” болно. Эдгээр мэдэгдлүүд нь “зорилго”, “зорилт”, “урьдчилан таамаглах”, “итгэх/таамаглах”, “болох”, “тооцох”, “найдах”, “хэрэв”, “төлөвлөх”, “магадлал”, “төлөвлөгөө”, “боломжтой”, “таамаг”, “төсөл”, “хэрэгтэй”, “болсон”, “болно” зэрэг бусад ижил төстэй нэр томъёогоор тодорхойлогдож болно. Гэсэн ч эдгээр нэр томъёо нь хэтийн төлөвийн таамаглалыг тодорхойлох цор ганц хэрэгсэл биш. Компанийн санхүүгийн байдал, бизнесийн стратеги, төлөвлөгөө, хэтийн төлөв, Компанийн үйл ажиллагаа явуулж буй салбарын хэтийн төлөв зэрэгтэй холбогдсон бүхий л мэдэгдэл нь хэтийн төлөвийн таамаглал болно. Компанийн орлогын ашиг ба өсөлт, хүлээгдэж буй ашиг ба өсөлт, хэтийн төлөв, төлөвлөгөө, салбарын бусад хандлага болон Компанитай холбоотойгоор Вайтпэйперт тусгагдсан бусад асуудлууд зэрэг хэтийн төлөвийн таамаглалууд нь түүхэн баримтууд бус тооцоолол, таамаглалууд болно.

Компани нь томъёолол, математик, шинжлэх ухааны загварчлал, таамаглал дээр үндэслэн өөрийн гаргасан аливаа таамаглал, тооцоо, дүгнэлт, магадлал, хүлээлт болон лавлагаа, бие даан явуулсан аливаа судалгаа, шинжилгээ болон холбогдох бусад зүйлсэд ямар нэгэн төлөөлөл, баталгаа гаргахгүй. Эдгээр хэтийн төлөвийн таамаглал нь мэдэгдэх, үл мэдэгдэх эрсдэл, тодорхой бус байдал болон Компанийн бодит ирээдүйн үр дүн, гүйцэтгэл, ололт, амжилт нь хэтийн төлөвийн мэдэгдлээр хүлээгдэж буй, шууд болон шууд бусаар илэрхийлэгдсэн аливаа үр дүн, гүйцэтгэл, ололт амжилтаас эрс ялгаатай байдлыг үүсгэж болзошгүй бусад хүчин зүйлсийг агуулдаг. Эдгээр хүчин зүйлсэд дараах хүчин зүйлсийг ойлгоно:

- Компани нь өөрийн бизнес болон үйл ажиллагаагаа, MNFT Койны худалдаа явуулж байгаа улсын хууль эрх зүй, улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хувьцаа криптовалютын зах зээлийн нөхцөл байдал болон зохицуулалтын орчин;
- Компани өөрийн бизнесийн стратеги болон ирээдүйн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх боломжгүй болох эрсдэл;
- Цаасан мөнгө /fiat currency/ болон криптовалютын хүүгийн хэмжээ, ханшийн өөрчлөлт;
- Компанийн хүлээгдэж буй өсөлтийн стратеги болон дотоод өсөлтийн өөрчлөлт;
- Бизнес, үйл ажиллагаатай нь холбогдуулан Компанид төлөх хүртээмж, хураамжийн өөрчлөлт;
- Компаниас бизнес, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хүний нөөцийн боломж, хүртээмжтэй байдал, цалингийн өөрчлөлт;
- Компанийн үйлчлүүлэгчдийн сонголтод гарсан өөрчлөлт;
- Компанийн үйл ажиллагаа явуулж буй өрсөлдөөний нөхцөл, өрсөлдөх чадварын өөрчлөлт;
- Компанийн ирээдүйн хөрөнгийн хэрэгцээнд гарсан өөрчлөлт, хэрэгцээг санхүүжүүлэх санхүүжилт, хөрөнгийн боломж;
- Дайн, олон улсын болон дотоодын терроризм;
- Компанийн бизнес болон үйл ажиллагаанд нөлөөлж буй гамшигт үзэгдэл, байгалийн гамшиг, хүний хяналтаас гадуур үйлдлүүд;
- Компанийн хяналтаас гадуурх бусад хүчин зүйлс;
- Компани болон түүний бизнес, үйл ажиллагаатай холбоотой MNFT, MNFT Койны худалдаа, Вайтпэйперт бүрэн эсхүл хэсэгчлэн найдсанаас үүссэн аливаа эрсдэл, тодорхойгүй байдал;

Компани эсхүл Компанийн төлөөлөгчдийн хийсэн болон ирээдүйд хийх аливаа таамаглал дээрх хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Компанийн цаашдын үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэл эсхүл ололт амжилт зэрэг “Хэтийн төлөвийн таамаглал”-д тусгагдаж илэрхийлэгдсэн үр дүнгээс бодитоор зөрөх буюу зөрчилдөх байдлыг харгалзан үзэж тухайн мэдэгдэлд үндэслэн шийдвэр гаргаж болохгүй.

Энэхүү хэтийн төлөвийн талаарх төсөөллийг Вайтпэйперийг нийтэд хүргэсэн өдөр болон түүнд оруулсан хамгийн сүүлийн өөрчлөлтийн хугацаанд хэрэглэж боломжтой. Компани эсхүл Компанийн төлөөлөгчид болон бусад этгээд нь Компанийн ирээдүйн ололт, амжилт нь хэтийн төлөвийн төсөөлөлд тусгасантай адил буюу ижил байхыг ямарваа нэгэн байдлаар баталгаа олгохгүй, баталгаажуулах үүргийг хүлээхгүй. Компанийн үйл ажиллагааны бодит үр дүн, гүйцэтгэл, ололт амжилт зэрэг нь хэтийн төлөвийн төсөөлөлд зааснаас ялгаатай байж болно.

Энэхүү Вайтпэйперт агуулагдсан мэдээлэл нь Компанийн ирээдүйн гүйцэтгэл, үйл ажиллагааны бодлогын талаар тухайлсан баталгаа, амлалтыг агуулаагүй. Цаашилбал, Компани нь хэтийн төлөвийн төсөөлөлийг шинэчлэх буюу өөрчлөлт оруулах эсхүл хэтийн төлөвийн төсөөлөлд нөлөөлөх ирээдүйн хөгжүүлэлт, үйл явдал эсхүл нөхцөл байдал, түүнээс гадна шинэ мэдээлэл нийтэд ил болсон эсхүл ирээдүйд бусад өөр үйл явдал тохиолдох талаар нийтэд үүргээсээ татгалзсан болно.

## НУУЦЛАЛЫН БОДЛОГО

MNFT Койныг худалдан авснаар худалдан авагч нь өөрийн хувийн мэдээлэл /өөрөөр хэлбэл, таны и-мэйл хаяг, овог нэр, хаяг болон бусад мэдээлэл/-ийг Компани бизнесийн зорилгоор болон ирээдүйн бүтээгдэхүүн, MNFT Койныг бий болгох, сурталчлах, Компанитай харилцах зорилгоор ашиглахыг зөвшөөрч байгаа болно. Компани нь таны имэйл хаяг болон бусад хувийн мэдээллийг чандлан нууцалж, олон нийтэд задруулахгүй байхыг (жишээлбэл, гадны жагсаалтад оруулах эсхүл гуравдагч этгээдэд зарах гэх мэт) зөвшөөрч байна

## ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

MNFT Койны арилжаанд оролцохоос өмнө энэхүү Вайтпэйперт дурдсан бүхий л мэдээлэл болон доорхи эрсдэлийн хүчин зүйлстэй бүрэн танилцаж, харгалзан үзнэ үү. Компанийн зүгээс дор дурдсан эрсдэлийн хүчин зүйлсийг MNFT Койны арилжаанд оролцох эсэх шийдвэр гаргахдаа харгалзаж үзвэл зохих хүчин зүйлс мөн гэж үзсэн болно. Дор дурдсан хүчин зүйлс, тодорхойгүй нөхцөл байдал, ноцтой эрсдэлүүд нь бодит байдал дээр үүсч бий болсон тохиолдолд тэдгээр нь Компанийн бизнес, санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүн болон токены нөхцөл байдал, хэрэглээнд ноцтой, сөрөг нөлөөлөл учруулна. Эдгээр ноцтой, сөрөг нөлөө, тодорхойгүй байдлын үр дүнд токены арилжааны үнэ (зохицуулалттай, зохицуулалтгүй, анхдагч, хоёрдогч эсхүл бусад аливаа бирж эсхүл захад байршсан) унаж, та токеныг эсхүл түүний эдийн засгийн үр өгөөжийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн алдах магадлалтай юм.

## MNFT КОЙНЫ ҮНЭ ЦЭНТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

MNFT Койн нь Вайтпэйперт заасан зорилго, онцлог, хэрэглээ, шинж чанарыг л агуулсан бөгөөд Вайтпэйперт дурдаагүй өөр зорилго, онцлог, хэрэглээ, шинж чанарыг агуулаагүй болно.

MNFT Койныг өмнө нь зах зээл дээр арилжиж байгаагүй тул, MNFT Койныг худалдсаны дараа түүний зах зээл дээр хөрвөх чадвар сул байх, үнэ нь ихээхэн тогтворгүй байх эрсдэлтэй. Хэдийгээр MNFT Койныг анхдагч зах зээл дээр амжилттай арилжсан ч түүний эрэлт хэрэгцээ хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсний дараа ч тогтвортой байх эсэх нь тодорхой бус юм. Хэрэв \$MNFT Койны хөрвөх чадварыг хангахуйц зах зээл үүсээхгүй бол MNFT Койны үнэ ихээхэн тогтворгүй болж, зарим тохиолдолд Койн эзэмшигч өөрийн эзэмшиж буй Койныг цаг тухайд худалдах, түүгээр гүйлгээ хийх боломжгүй байж болзошгүй.

MNFT Койны үнэ буурч болох бөгөөд Компани нь \$MNFT Койны хөрвөх чадварын талаар аливаа баталгаа, мэдэгдэл гаргаагүй болно. Компани нь гуравдагч этгээдээр дамжуулан эсхүл бусад байдлаар бий болсон MNFT Койныг зах зээлийн үнийн өөрчлөлт, MNFT Койны шилжих, хөрвөх чадвар эсхүл зах зээл дэх хүрэлцээт байдлын хувьд аливаа байдлаар хариуцлага хүлээхгүй.

өрөө хариуцна

MNFT Койныг худалдахтай холбоотой холбогдох хууль тогтоомжид тусгайлан зааснаас бусад тохиолдолд Компани нь MNFT Койн эзэмшигчийн MNFT Койныг буцаан худалдан авах үүрэг хүлээхгүй. Иймд MNFT Койн эзэмшигч нь MNFT Койныг Компанид буцаан шилжүүлэх, ийнхүү шилжүүлсний хариу төлбөр болгон мөнгө, нөхөн төлбөр авах, шаардах эрхгүй. Компани нь MNFT Койнтой холбоотой анхны үнэ, үргэлжилсэн төлбөр төлөлт болон MNFT Койны үнэ цэнийн тухай зэргийг оролцуулан аливаа ирээдүйн үйлдэл эсхүл үнийн талаар аливаа амлалт өгөхгүй.

MNFT Койн, MNFT Койны арилжаатай холбоотой сөрөг агуулга бүхий мэдээ, мэдээлэл нь түүнийг залруулсан эсэхээс үл хамааран зах зээлийн талаарх ойлголт болон зах зээлийн үнэд их хэмжээгээр, сөргөөр нөлөөлж болно.

MNFT Койнд хамаарах татварын төрөл нь тодорхой бус юм. Худалдан авагч нь MNFT Койныг олж авах, хадгалах, шилжүүлэх, ашиглахтай холбоотойгоор (суутган татвар, шилжүүлгийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, орлогын албан татвар болон бусад адилтгах татвар, татаас, хураамж болон бусад төлбөр, татвар тайлагнах шаардлагуудыг оролцуулан, гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй) татварын зөвлөгөө авах асуудлаа өөрөө хариуцна.

## БЛОКЧЭЙН БА ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ЭРСДЭЛ

Криптовалютын гүйлгээнд ашиглагддаг ихэнх блокчэйнүүд (Итэриум, БитКойн гэх мэт) дээр блок үйлдвэрлэх цаг нь хийгдэж буй ажлаас хамааралтай байдаг тул өөр өөр цагуудад блок үйлдвэрлэл явагдаж байдаг. Тухайлбал, токенийг худалдахад MNFT Койны төлбөрт хамгийн сүүлд хийгдсэн криптовалюта нь тухайн цагтаа багтаж орохгүй байж болно. Холбогдох блокчэйн нь худалдан авагчийн гүйлгээг түүний тооцоолсон цагт амжиж хийхгүй байх магадлалтай буюу MNFT Койны төлбөр нь очих ёстой хэтэвчиндээ худалдан авагч криптовалютыг илгээсэн өдөр очихгүй байх магадлалтай.

Криптовалютын гүйлгээнд ашиглагддаг ихэнх блокчэйнүүд (Итэриум, БитКойн гэх мэт) нь тодорхой давтамж бүхий ачаалалд өртөж, түүний улмаас гүйлгээ хойшлох, цуцлагдах нь элбэг. Мөн хувь хүмүүс криптограф MNFT Койн худалдан авахдаа өөртөө давуу байдал үүсгэх зорилгоор санаатай сүлжээнд ачаалал үүсгэх оролдлого хийж болно. Үүнээс үүдэн худалдан авагчийг хүссэн үед нь эсхүл ямар ч тохиолдолд блок үйлдвэрлэгчид нь худалдан авагчийн гүйлгээг орхигдуулахад хүргэх аюултай

Токений ухаалаг гэрээ гэх шийдэл дэх суурь програм хангамжийн аппликэйшн, платформ нь (Итэриум, БитКойн гэх мэт) өнөөг хүртэл хөгжлийн эхэн шатандаа явж буй. MNFT Койныг бүтээх үйл ажиллагаа нь тасалдалгүй, алдаагүй байна гэсэн аливаа мэдэгдэл, баталгааг Компани гаргаагүй болно. Програм хангамжин сул тал, өртөмтгий байдал, алдаа, мөн криптовалюта эсхүл MNFT Койн тэр чигтээ үгүй болох зэрэг програм хангамжийн өөрийн онцлог чанартай холбоотой эрсдэлүүд байсаар байгааг анхаарна уу. MNFT Койн арилжаа, MNFT Койн болон Вайтпэйперт дурдсан бусад асуудал нь бүхэлдээ шинэ буюу туршигдаагүй болно. MNFT Койн арилжаа болон MNFT Койны хөгжүүлэлт нь төлөвлөгөөний дагуу ажиллахгүй байж болно. Хэдийгээр аппликэйшн нэвтрүүлж ашиглалтад оруулсан ч гэлээ төлөвлөсөн функц нь ажиллахгүй эсхүл үнэ цэн бий болгохгүй байж болох эрсдэлтэй. Түүнчлэн, технологи хурдацтай хөгжиж, өөрчлөгдөж байгаагийн хэрээр MNFT Койн болон MNFT Койны арилжаа нь технологийн хувьд хуучрах магадлалтай юм.

## АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛ

MNFT Койн эзэмшигч нь Койныг өөрийн дижитал хэтэвч эсхүл сэйфт хийн эзэмших бөгөөд нэвтрэхийн тулд хувийн түлхүүр эсхүл түлхүүрүүдийн нэгдлийг шаарддаг. Иймээс хувийн түлхүүрээ алдсан бол MNFT Койн эзэмшигч нь MNFT Койн болон гуравдагч этгээдийн бий болгосон блокчэйн дэх үлдэгдлээ мөн алдана гэсэн үг юм. Улмаар түлхүүрийг олж авсан аливаа этгээд нь Койн эзэмшигчийн токенийг хууль бусаар захиран зарцуулах нөхцөл бүрдэх эрсдэлтэй.

Хакерууд, бусад хорлонт бүлэглэл, байгууллагууд нь халдлага, үйлчилгээний халдлагын эсэргүүцэл, зөвшилцөлд суурилсан халдлага, Sybil халдлага, смурфинг, спүүфинг зэрэг байдлаар MNFT Койн болон олон төрлийн MNFT Койныг бүтээдэг токен, ухаалаг гэрээнд саад учруулахаар оролдож болзошгүй. Түүнчлэн, Итэриум платформ нь нээлттэй програм хангамжид суурилдаг учраас Итэриум ухаалаг гэрээнүүд нь санаатай болон санаатай бус согог, дутагдлыг агуулж болох ба энэ нь MNFT Койн, түүнийг үгүй болгох, MNFT Койнд нэвтрэх болон хянах боломжийг алдах эрсдэлийг бий болгож болзошгүй. Програм хангамжид согог, дутагдал илэрсэн тохиолдолд тухайн бүрт түүнийг залруулах боломжгүй байж болох бөгөөд энэ тохиолдолд MNFT Койн эзэмшигч нарт залруулах арга хэмжээ, буцаалт эсхүл нөхөн төлбөр өгөх баталгааг Компани гаргаагүй болно.

Худалдан авагч MNFT Койноо нээлттэй түлхүүртэй холбоогүй бол тухайн худалдан авагчийн аккаунт нь гуравдагч талууд түүний токены үлдэгдлийг Итэриум блокчэйн дээр танихгүй байх нөхцөлд хүргэж болзошгүй.

MNFT Койныг олж авах болон хадгалахтай холбоотойгоор хэтэвч нь эсхүл хэтэвчний үйлчилгээ үзүүлэгч нь MNFT Койнтой нийцэлтэй байх ёстой. Үгүй бол MNFT Койныг эзэмшигч нь өөрийн Койндоо нэвтэрч чадахгүй болно.

Манай Компани MNFT Койн худалдаанаас олсон хөрөнгийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар найдвартайгаар барих бүхий л хүчин чармайлтыг гаргаж ажиллана. Тэдгээр арга хэмжээг Итэриум эсхүл бусад блокчэйн дээрх ухаалаг гэрээнд үүссэн хак, цахим халдлага, алдаа зэргээс үүдсэн криптовалютын хулгай гарахгүй гэсэн баталгаа байхгүй юм. Тэдгээр тохиолдлууд нь програмчлалын эсхүл эх код зэргээс үүдэлтэй алдаа байж болно. Энэ тохиолдолд, Койны анхдагч зах зээлийн арилжаа явагдсан ч гэлээ Компани нь босгосон хөрөнгийг хүлээн авч, түүнийг апп, MNFT Койны худалдаа болон бусад ирээдүйн бизнесийн үйл ажиллагаандаа хэрэглэх боломжгүй болно. Ингэснээр MNFT Койн худалдах үйл явц амжилттай болсон ч гэсэн хөрөнгийг хүлээн авч, түүнийг ирээдүйн бизнесийн үйл ажиллагаандаа хэрэглэх боломжгүй болох юм. MNFT Койны үйл ажиллагаа түр хугацаагаар эсхүл тэр чигтээ зогсох эрсдэлтэй. Мөн хуваарилсан MNFT Койн нь маш бага үнэ цэнтэй болж энэ нь арилжааны үнэд нөлөөлөх магадлалтай

## КОМПАНИТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Компани нь хэдийгээр түүний засаглалын бодлого, MNFT Койны бодлогыг хэрэгжүүлэх боловч бизнесийн хувьсал, өрсөлдөөн, эдийн засгийн нөхцөл байдал, шинээр батлагдсан хууль тогтоомж, үр ашиггүй удирдлага буюу удирдлагын буруу тооцоолол зэрэг нь Компани, түүний гаргасан MNFT Койнд сөрөг үр нөлөө үзүүлж болзошгүй.

Манай Компанийн өрсөлдөж буй салбар нь сүүлийн хэдэн жилд хурдацтайгаар өсч томрон, бизнесийн өрсөлдөөнийг бий болгож, шинэ технологийн хөгжил дэвшил нь бизнесийн модел, загварыг өөрчилж байна. Энэхүү дэвшил, өөрчлөлтийн үр нөлөөгөөр бидэнд өөрчлөлтөд дасан зохицох бэрхшээл тулгарч болзошгүй ба Компанийн тогтвортой байдал нь Компанийн үйл ажиллагааны менежментийг боловсруулж хэрэгжүүлэх чадвар, чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэх, тэдгээрийг тогтмол сургаж, мэдлэг чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаанаас хамаарах билээ. Манай бизнес өргөжин тэлэхийн хэрээр Компани үйл ажиллагааны бүтцээ өргөжүүлэх, шинэчлэх шаардлагатай. Манай Компани зах зээл дээр амжилттай өрсөлдөж чадна гэдэг баталгааг бид өгч чадахгүй.

Дэлхий дахинд тулгарч буй эдийн засгийн сорилт нь мэдээллийн технологийн салбарын хөгжлийг бүхэлд нь удааширхад нөлөөлсөөр байна. Эдийн засгийн сулрал нь манай бизнес, үйл ажиллагаа, санхүүгийн байдалд нөлөөлж, хөрөнгө оруулалт татах, зээл авах зэрэг бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө. Цаашлаад, эдийн засгийн сулралын үр дүнд манай Компанийн арилжаа болон MNFT Койны худалдаа, хэрэглээнд удаашрал үүсч болзошгүй.

Манай Компани нь өөрийн патент, барааны тэмдэг, барааны тэмдгээр баталгаажуулахгүй нөхцөл болон худалдааны нууцад үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг ба ингэхдээ өөрсдийн нөхцөл, бизнесийн нууцыг ажилтан, зөвлөхүүдтэйгээ нууц хадгалах гэрээ байгуулах зэрэг аргаар хамгаалдаг. Гэвч эдгээр арга хэрэгсэл нь Компанийн оюуны өмчийг бүрэн хамгаалах боломжгүй бөгөөд бид гуравдагч этгээд биднээс илүү сайн аргаар бүтээгдэхүүн хөгжүүлэх нөхцөл, худалдааны нууцыг бие даан хөгжүүлэх боломжгүй гэх баталгаа өгч чадахгүй юм.

Компанийн өрсөлдөгч хуулийн этгээд, хувь хүн нь манай бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбогдох оюуны өмчийг хууль ёсоор эзэмшдэг талаар эсхүл эзэмших шаардлага бүхий нэхэмжлэл гаргаж болно. Мөн гуравдагч этгээдийн зүгээс манай Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, ашиглаж буй технологи нь тэдний оюуны өмчийн эрхийг зөрчиж байгаа гэж үзэн шаардлага, нэхэмжлэл гаргаж болно. Компанийн бүхий л эсхүл зарим технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь бусдын оюуны өмчийн эрхэд хамаарч байсан эсэхийг бид бүрэн дүүрэн мэдээгүй байж болно.

## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮҮСЭХ ЭРСДЭЛ

Компанийн эрх бүхий албан тушаалтан зарим тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэлд орох, энэ тохиолдолд зах зээлийн зүй ёсны бус нөхцөл бүхий гэрээ байгуулагдах зэрэг ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал үүсч болно.

Компаниас аливаа этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэлд хэрэглэсэн хуулийг өөрөөр тайлбарлах, эсхүл тухайн хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцсоны улмаас Компани өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах боломжгүй болж, улмаар энэ нь MNFT Койнд сөрөг нөлөө үзүүлж болно.

Манай Компани нь хөгжиж буй зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг болно. Хөгжиж буй зах зээл нь хөгжингүй зах зээлээс хууль эрх зүй, эдийн засаг, улс төрийн эрсдэлээр илүү байдаг. Шинээр бий болж буй зах зээл нь маш хурдацтайгаар өөрчлөгддөн шинэчлэгддэг тул Вайтпэйпер дах мэдээлэл богино хугацаанд хуучирч болно.

# ТӨРИЙН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН БУЮУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЭРСДЭЛ

Улс орнуудад криптограф, цахим хөрөнгө, блокчэйн технологи зэрэгт холбогдох хууль эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байдалтай байна. Улс орнуудын төрийн эрх бүхий байгууллагаас криптограф, цахим хөрөнгө, блокчэйн технологи, тэдгээрийн хэрэглээ зэргийг зохицуулсан хууль тогтоомжид, эрх зүйн актад ямар төрлийн өөрчлөлт оруулах, эсхүл шинээр батлахыг урьдчилж таамаглах боломжгүй. MNFT Койныг бүртгүүлдэг байх зэргээр журамласан хууль тогтоомж батлах нь MNFT Койнд сөргөөр нөлөөлөх магадлалтай. Хэрвэл холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас MNFT Койныг хууль бус хөрөнгөд тооцсон эсхүл зохисгүй хөрөнгө гэж үзсэн тохиолдолд Компани нь MNFT Койны худалдаа, Компанийн бизнесийн үйл ажиллагаа зэргийг зогсоож болзошгүй.

Монгол Улсын хууль тогтоох эрх бүхий байгууллагын хэмжээнд Цахим хөрөнгийн тухай хуулийн хэлэлцүүлэг өрнөж байгааг бид ойлгож байгаа ба уг хууль, түүнийг дагалдуулан ямарваа эрх зүйн акт батлан гаргасан тохиолдолд тэдгээр нь MNFT Койнд хэрхэн нөлөөлөхийг бид урьдчилан таамаглах боломжгүй байна. Хэрэв тус хууль батлагдан гарснаар MNFT Койныг хууль бус хөрөнгөд тооцсон эсхүл зохисгүй хөрөнгө гэж үзсэн тохиолдолд Компани нь MNFT Койны худалдаа, Компанийн бизнесийн үйл ажиллагаа зэргийг зогсоож болзошгүй.

MNFT Койныг анхдагч зах зээлд гаргах үеийн байдлаар Компани үйл ажиллагаа явуулахад холбогдуулан аливаа тусгай зөвшөөрөл авах үүрэг ногдуулсан хууль тогтоомж батлагдаагүй, хэрэгжээгүй байгаа ч ирээдүйд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл авсан байхыг үүрэг болгосон хууль тогтоомж батлагдахыг үгүйсгэхгүй. Энэ тохиолдолд тухайн тусгай зөвшөөрлийн нөхцөл, хүчин төгөлдөр байдал, тусгай зөвшөөрлийн хугацаа зэргээс Компанийн үйл ажиллагаа үргэлжлэх эсэх хамаарна. Төрийн эрх бүхий буюу зохицуулагч байгууллага нь тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа, хугацаа сунгах болон тусгай зөвшөөрөлд холбогдох журмын дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа эсэхэд хяналт тавих бүрэн эрхтэй байдаг. Ийнхүү төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагаас тогтоосон шаардлага нь Компанид хэд хэдэн стандартыг хангах, тусгай мэргэжилтэн, боловсон хүчинг ажиллуулах, тоног төхөөрөмж, хяналтын систем, хүсэлт, гомдол шийдвэрлэх механизм зэргийг бий болгохтой холбоотой шаардлага тавьсантай холбоотой шаардлага нь хөрөнгө мөнгө, цаг хугацаа ихээр шаардах тул Компанийн үйл ажиллагаанд доголдол үүсгэж болно. Цаашлаад, хувь хүн, олон нийтийн зүгээс төрийн эрх бүхий байгууллага (шүүхийн байгууллага гэх мэт)-д нөлөөлөх замаар болон улс төрийн шинжтэйгээр Компанийн тусгай зөвшөөрөл авах ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг үгүйсгэхгүй. Үүнээс үүдэн Компани, түүний холбогдох этгээдүүд нь шаардлагатай тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжид

заасан хугацаанд авч чадахгүй эсхүл хугацааг сунгуулж чадахгүй байх боломжтой ба энэ нь Компанийн үйл ажиллагаа эрхлэх, ашиг орлого олоход хязгаарлалт үзүүлж болно.

Бидний үйл ажиллагаа эрхэлж буй салбар нь шинэ учир тухайн салбарт албадлагын шинжтэй төрийн хяналт шалгалт, хязгаарлалт тавигдаж болно. Төрийн байгууллагаас Компанийн эсрэг түүний үйл ажиллагааг хянах, тодорхой албадлагын арга хэмжээг авахгүй гэсэн баталгаа байхгүй. Эдгээр нь биднийг тодорхой шүүхийн шийдвэр, хэлэлцээр, торгууль, төлбөрийн үүрэг, эсхүл бүтэц зохион байгуулалтаа өөрчлөх, бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгохоо зогсоох зэрэг бидний нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн эсхүл их хэмжний зардал гаргах шаардлагыг бидэнд учруулах болзошгүй ба энэ нь MNFT Койн, түүний арилжаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

Хүчин төгөлдөр хууль тогтоомжийг дагаж мөрддөггүй, эсхүл төрийн эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийх, бидний үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг чангатгах зэрэг нь биднээс хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой нэмэлт зардал гаргаж, үйл ажиллагааны хязгаарлалт үүсгэж болзошгүй ба энэ нь Компанийн бизнес, MNFT Койнд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Төрийн эрх бүхий байгууллага нь холбогдох хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх бүрэн эрхийнхээ хүрээнд жилийн аль ч үед Компанийн үйл ажиллагаа, эд хөрөнгөд хяналт шалгалт хийж болно. Эдгээр хяналт шалгалтын үр дүнд Компанийг холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзэх, Компани тухайн зөрчлийн талаарх дүгнэлтийг эсэргүүцэх эсхүл арилгах арга хэмжээ авч чадахгүй байж болзошгүй. Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжыг дагаж мөрддөггүй эсхүл төрийн эрх бүхий байгууллагын хяналт шалгалтын үр дүнд Компанид төлбөрийн үүрэг, торгууль ногдуулах, шийтгэл хүлээлгэх, Компанийн үйл ажиллагааг тодорхой хүрээнд хязгаарлах, эсхүл Компанийн эрх бүхий албан тушаалтанд эрүүгийн ба захиргааны хариуцлага хүлээлгэхийг үгүйсгэхгүй. Компанийн үйл ажиллагааны талаарх төрийн эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргах, шаардлага тавих, хязгаарлалт тогтоох, хяналт тавих нь бидний зардлыг нэмэгдүүлж, үйл ажиллагаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

Төрийн эрх бүхий байгууллагууд өөрийн бүрэн эрхийн хүрээнд Компанийн санал, тайлбарыг авахгүйгээр, урьдчилан мэдэгдэл өгөхгүйгээр эсхүл улс төрийн болон ашиг сонирхлын зерчилтэйгээр хууль зөрчих замаар ямарваа үйлдэл хийхийг үгүйсгэхгүй. Мөн төрийн эрх бүхий байгууллагаас тодорхой тохиолдлуудад зохицуулалт хийх, гэрээний үүргийн гүйцэтгэлд хөндлөнгөөс оролцох, саад учруулах, гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох, цуцлахыг шаардах зэрэг ажиллагааг хэрэгжүүлж болно. Хууль бус, селектив, албадлагын шинжтэй эдгээр үйлдлүүдэд тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах, түдгэлзүүлэх, гэнэтийн болон төлөвлөгдөөгүй татварын хяналт шалгалт, эрүүгийн мөрдөн шалгах болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хамаарна.

Төрийн эрх бүхий байгууллагууд нь токен худалдах асуудлыг тойрсон нийтлэг сул талуудыг ашиглан, ихэнхдээ улс төрийн зорилгоор холбогдох хэлцлийг хүчингүйд тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах байдлаар хандах тохиолдууд бий. Ийм орчин нөхцөл нь бидний өрсөлдөгчийн хувьд төрөөс хүртэж буй харьцангуй таатай нөхцөл болж байна.

Блокчэйн технологи, криптограф Койнууд нь харьцангуй шинэ, динамик шинжтэй технологи юм. Дээр дурдсан эрсдэлүүдээс гадна MNFT Койн худалдан авалт, эзэмшил, хэрэглээтэй холбоотой бидний тооцоолоогүй эрсдэл байж болно. Эдгээр эрсдэлүүд нь урьдчилсан тооцоогүй байдлаар эсхүл өмнө дурдсан эрсдэлүүдтэй холимог байдлаар илэрч болно.

# МЭДЭЭЛЭЛ АВСАН ЭХ СУРВАЛЖУУД



# ЭХ СУРВАЛЖУУД

Louis DeNicola, "What To Know About Non-Fungible Tokens (NFTs) — Unique Digital Assets Built On Blockchain Technology", Business Insider, 2021  
<https://www.businessinsider.com/nft-meaning>

Salter, Tom, "The NFT Landscape", Bytetreelab, 2021  
<https://bytetreelab.com/insights/2020/10/the-nft-landscape/>

"Nifty Gateway", Niftygateway.com, 2021  
<https://niftygateway.com/profile/grimes>

"People Are Spending Millions On NFTs. What? Why?", The Verge, 2021  
<https://www.theverge.com/22310188/nft-explainer-what-is-blockchain-crypto-art-faq>

"Beeple's Masterwork: The First Purely Digital Artwork Offered At Christie's | Christie's", Christies.com, 2021  
[https://www.christies.com/features/Monumental-collage-by-Beeple-is-first-purely-digital-artwork-NFT-to-come-to-auction-11510-7.aspx?sc\\_lang=en](https://www.christies.com/features/Monumental-collage-by-Beeple-is-first-purely-digital-artwork-NFT-to-come-to-auction-11510-7.aspx?sc_lang=en)

"Axie Infinity - Axie Infinity", Whitepaper.Axieinfinity.Com, 2021  
<https://whitepaper.axieinfinity.com/>

"Cryptopunks", Larvalabs.com, 2021  
<https://www.larvalabs.com/cryptopunks>

"Introducing \$RARI—The First Governance Token In The NFT Space", Medium, 2021  
<https://rarible.medium.com/introducing-rari-the-first-governance-token-in-the-nft-space-5dbcc55b6c43>

"Mongol NFT", Mongolnft.com, 2021  
<https://mongolnft.com/drops>

Labs, Dapper, "NBA Top Shot: LeBron James - Owned By Kyaloren", NBA Top Shot, 2021  
<https://nbatopshot.com/moment/kyaloren+5408a71c-50f1-4588-86e3-354b40519ce3>

"Онц Дүмд Special NFT By Beernightstudio", Mongolnft.com, 2021  
<https://mongolnft.com/collections/61435e6f1dc64700120d928d>

"Decentraland", Play.Decentraland.org, 2021  
<https://play.decentraland.org/>



# АНХААРАЛ ТАВЬСАН ТАНД БАЯРЛАЛАА!



**POWERED BY:** Mongol NFT  
[www.mongolnft.com](http://www.mongolnft.com)